

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгмийн хэв маягийг ангилсан бодомжид хамааралгүй нь аль вэ? (1оноо)
A. Агнуурын болон түүвэрлэгчдийн
B. Газар тариалангийн
C. Хүн төрөлхтний соёлт
D. Аж үйлвэржсэний дараах
E. Аж үйлдвэржсэн
2. Нийгмийн харилцаа гэсэн ойлголт аль нь вэ? (2 оноо)
A. Хүний эрх, үүргийн нэгдлийн харилцаа
B. Хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн хооронд тогтсон харьцангуй тогтвортой бие даасан холбоо хамаарал
C. Өмчийн болон хуваарилтын харилцаа
D. Хувь хүн хийгээд бүлэг хоорондын харилцааны сүлжээ
E. Аль нь ч биш
3. Иргэний нийгмийн (өргөн утгаар) ойлголтод тохирох хариулт аль нь вэ? (1оноо)
A. Хүн эрх чөлөөгөө хэрэгжүүлэх таатай орчин
B. Янз бүрийн эрх ашиг, сонирхол бүхий нийгмийн бүлгүүдээс бүрдсэн нийгмийн бүтэц
C. Иргэн бүрийн хувийн эрх чөлөө, сонирхлыг дээдэлсэн нээлттэй нийгмийн тогтолцоо
D. Нийгмийн хөгжлийн жам ёсны төлөв байдал
E. Нийгэм дэх төрийн бус бүх төрлийн харилцаа
4. Дорж үйлдвэрт ажилладаг бөгөөд тэрээр тэргүүний ажилчдын нэг юм. Эдгээр шинж нь аль ойлголтод хамаарах вэ? (2 оноо)
A. Онцгой хүн B. Хувь хүн C. Суут хүн D. Бие хүн E. Хангалуун сэтгэлтэй хүн
5. “Нийгэм бол бусад хүмүүс болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл мөн” гэж хэн үзсэн бэ? (1 оноо)
A. К. Маркс B. Т. Парсонс C. М. Вебер D. Э. Дюркгейм E. В.И. Ленин
6. Мэдээлэл цуглуулах асуулга\ анкетын арга\ -ын гол зорилго аль нь вэ? (1оноо)
A. Үзэгдэл, үйл явцын тухай мэдээлэл агуулсан бичиг баримт, бусад материаллаг эх сурвалжид шинжилгээ хийх замаар нийгмийн үйл явцыг таньж мэдэх
B. Судлах гэж байгаа үзэгдэл, үйл явцын талаар судлаач өөрөө оролцох юмуу эсхүл оролцохгүй ажиглах замаар мэдээлэл цуглуулах
C. Урьдчилан боловсруулсан асуултын дагуу хувь хүн, хамт олон, бүлгийн нийгмийн үйл байдлыг тандан судлах
D. Зориуд бэлтгэсэн тусгай орчин нөхцөлд үзэгдэл үйл явцыг давтах, үргэлжлүүлэх замаар мэдээлэл цуглуулж хувь хүн, хамт олон, бүлгийн зан авирт шинжилгээ хийх
E. Нийгмийг бүрдүүлж байгаа, улс төр, эдийн засаг, оюун санаа, социал амьдрал болон нийгмийн институт, бүлгийн дотоод дахь талуудын үүргийг задлан шинжлэх
7. Анализын аргын мөн чанарт аль нь тохирох вэ? (2 оноо)
A. Тусгай тусгай юм үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл дүгнэлт гаргах
B. Ямар нэг онол, үндэслэл, ерөнхий дүгнэлт зэргээс түүнд холбогдох бүлэг юмуу, бодгаль зүйлд хамруулсан дүгнэлт хийх
C. Бүх л зүйлийг бүрэлдэхүүн хэсэг, нэгжид нь сэтгэхүйдээ салган хувааж задлах
D. Танин мэдэгдсэн нэгж, салангад хэсгүүдийг нэг цогцод оруулан сэргээн холбож нэгтгэн дүгнэх
E. Нийгмийн үзэгдэл, үйл явцад судлаач өөрөө оролцох юм уу, оролцохгүй ажиглах замаар мэдээлэл цуглуулах

8. Боловсролын институтын үүрэг аль нь вэ? (1 оноо)
А. Мэдлэг, соёлыг дамжуулах, бүтээх, өсвөр үеийг нийгэмшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх
В. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах, бүлэг болон нийгмийг зохицуулах
С. Бараа үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэгцээг хангах
D. Үр удмаа нөхөн үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх
E. Үл мэдэх ба мэдэж болохгүй зүйлст хариулт өгөх, нийгмийн эв нэгдэл, зөвшилцөл тогтоох
9. Хүний анхдагч нийгэмшил аль нь вэ? (1 оноо)
А. Хамт олон В. Нийгмийн бүлгүүд С. Байгаль орчин
D. Гэр бүл E. Сургууль
10. Нийгэмшилт нь цаг хугацааны хувьд хүнд хэрхэн явагддаг вэ? (1 оноо)
А. Хүүхэд эхээс төрмөгц В. Өсвөр залуу насанд С. Ахмад насанд
D. Хүний насан туршид E. Дээрх бүгд
11. Нийгэм гэсэн ойлголтын (явцуу утгаар) тодорхойлолт аль нь вэ? (2 оноо)
А. Хүмүүсийн эргэн тойрон, хүрээлэн буй орчин
В. Олон тооны бодгаль, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал
С. Хүмүүсийн зохион байгуулалттай, чиглэсэн зорилготой харилцаа үйл ажиллагааны системийн хооронд болдог нэгдэл
D. Байнгын нутаг дэвсгэртэй улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар тогтнолтой, бие даасан соёлтой хүмүүсийн том нийтлэг
E. Дээрх бүгд
12. Улс төр гэдэг нь нийгмийн гишүүдийн эрс зөрүүтэй байдлаас шалтгаалаад тусгай арга хэрэгсэлгүйгээр шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд нийгэмд хамтын шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх.....юм. (2 оноо)
А. Арга зам В. Бодлого чиглэл С.Хандлага
D. Үйл ажиллагаа E. Нөхцөл байдал
13. Хүмүүнлэгийн (гуманизм) гол үзэл санаа аль вэ? (1 оноо)
А. Аливаа тогтолцоо ямагт шатлан захирагдсан байх ёстой
В. Аливаа тогтолцоо ерөнхий ба тодорхойгоос бүрдсэн байх ёстой
С. Аливаа тогтолцоо хүний хэрэгцээ сонирхлыг ямагт тэргүүн зэрэгт тавьж байх ёстой
D. Аливаа тогтолцоо “оролт”, “гаралт”, “эргэх холбоо”-оос бүрдсэн байх ёстой.
E. Дээрх бүгд зөв
14. Улс төр гэдэг нь “хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авах” асуудал гэж хэн үзсэн бэ? (1 оноо)
А. К. Маркс В. Р. Даль. С. Х. Лассуэл D. Аристотель E. М. Вебер
15. Улс төрийн засаглалын харилцааны онцлог аль нь вэ? (2 оноо)
А. Тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар объектоо хянах
В. Нийгмийн улс төрийн амьдралын хүрээнд үйлчилж буй засаглалын хэлбэр
С. Эрх мэдлийг хэрэгжүүлэх тэгш биш зорилт, харилцаанаас үүдсэн захирамжлах үйл ажиллагаатай холбогддог
D. Төрийн засаглалыг авах, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдон улс төрийн субъектүүдийн хооронд тогтвортой байнгын бодит харилцаа үүсэн бий болох
E. Нийгмийн бүлгүүдийн харилцаанд нэг юм уу хэд хэдэн бүлгээс өөрсдийн хүсэл зоригийг нийгмийн бусад хэсэгт тулган хүлээлгэх буюу хүлээн зөвшөөрүүлэх чадвар

16. Улс төрийн тогтолцоог бүтцийн талаас авч үзсэн зөв хариултыг олно уу. (2 оноо)
A. Нийгмийн улс төрийн тогтолцоо бол нийгэмд үнэт зүйлийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа
B. Нийгмийн улс төрийн тогтолцоо бол улс төрийн харилцааны аливаа төрлийг зохицуулагч бүх байгууллага, тэдгээрийн хооронд үүсдэг харилцан үйлчлэл, тэнд хэрэгждэг хэм хэмжээ, үнэт зүйлс зэргийн нийлбэр цогц
C. Нийгмийн улс төрийн тогтолцоо бол нэг нь нөгөөтэйгөө улс төрийн шалтгаан, үр дагавараар нөхцөлдсөн зохих дэс дараатай, системлэг үйл явдлуудын нийлбэр цогц
D. Нийгмийн улс төрийн тогтолцоо бол хүмүүсийн харилцааг зохицуулагч систем
E. Аль нь ч биш
17. Засаглалын үндсэн хэмжигдэхүүнийг тоочиход тохирохгүйг олно уу. (1 оноо)
A. Засаглалын хэм хэмжээ B. Засаглалын эзлэхүүн C. Засаглалын цаг хугацаа
D. Засаглалын легитим шинж E. Засаглалын орон зай
18. Монгол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудаас илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
A. Ардчилсан, шударга ёс B. Эрх чөлөө, тэгш байдал C. Эв нэгдэл
D. Намын үзэл баримтлалыг сахих E. Хууль дээдлэх
19. Улс төрийн намын онцлог шинж аль нь вэ? (1 оноо)
A. Намын ангийн шинж B. Намууд гишүүнчлэлтэй байх
C. Төрийн хэмжээнд засаглалыг авах, эсвэл түүнд оролцох зорилго
D. Нам үйл ажиллагаагаа зөвхөн сонгуулиар хязгаарлах
E. Нам боловсон хүчнээ бэлтгэх
20. Хүмүүсийн амьдралын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад түлхүү чиглэсэн бодлого явуулах зорилготой төрийн хэв маяг аль нь вэ? (2 оноо)
A. Эрх зүй төр B. Төрийн хэлбэр C. Төрийн дэглэм
D. Социал төр E. Авторитар төр
21. Ардчиллын үндсэн зарчимд аль нь үл тохирох вэ? (2 оноо)
A. Тэгш эрх B. Хууль дээдлэх C. Нэг намын тогтолцоо
D. Хүний эрх, эрх чөлөө E. Ил тод байдал
22. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид нь . . . юм. (2 оноо)
A. Засаг захиргааны байгууллага B. Төрийн удирдлагын байгууллага
C. Нутаг дэвсгэрийн байгууллага D. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага
E. Намын байгууллага
23. Социал төрийн бодлого юунд тулгуурладаг вэ? (2 оноо)
A. Ард түмний сэтгэл хөдлөл, тэвчээргүй байдал
B. Цөөнхийн дарангуйлалд
C. Нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг өмгөөлсөн бодлогод
D. Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх үйл ажиллагааны практик үр дүнд
E. Бизнесийн орчинд
24. 1990 онд Монгол улсад ардчилсан хувьсгал гарахад ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ? (2 оноо)
A. Нэг намын тогтолцооны монополь байдал
B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үр ашиггүй байдал
C. Нэг үзэл суртлын хуваарьгүй явцуурал
D. ЗХУ-ын задрал, социалист системийн мухардал
E. Дээрх бүгд

25. Хүний амьдрал, оршихуйн хэвийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нийгмийн байдлыг юу гэж нэрлэх вэ? (2 оноо)
А. Гачигдал В. Ядуурал С. Хомсдол D. Үгүйрэл E. Хоосрол
26. Инфляци, ажилгүйдлийг аль нь судлах вэ? (1 оноо)
А. Олон улсын санхүү В. Нягтлан бодох бүртгэл С. Макро эдийн засаг
D. Микро эдийн засаг E. Аль нь ч биш
27. Чөлөөт зах зээлийн тогтоолцооны шинжүүдийг тоочиход тохирохгүй нь аль вэ? (2 оноо)
А. Хувийн өмч В. Төвлөрсөн төлөвлөгөөт зохион байгуулалт
С. Ашиг олох D. Төрийн оролцоо хязгаарлагдмал байх
E. Өрсөлдөөн
28. Иргэн Дорж “TOYOTA” маркийн шинэ суудлын автомашин авах сонирхолтой боловч мөнгөний боломж тааруугаас хуучивтар “MITSUBUSHI” маркийн автомашин авчээ. Энэ тохиолдолд ашигт чанарын ойлголтод аль нь хамаарах вэ? (2 оноо)
А. Сонголт В. Сонгогдоогүй боломжийн өртөг С. Эрэлт
D. Нийлүүлэлт E. Хүлээлт
29. Эдийн засаг, үйлдвэрлэлийн нөөц баялгийн ангилалд тохирохгүй хариултыг олно уу? (1 оноо)
А. Газар В. Хөдөлмөр С. Капитал
D. Уулын горхины ус E. Үйлдвэрлэл эрхлэх ур чадвар
30. Инфляцийн шалтгаан юунд орших вэ? (2 оноо)
А. Гүйлгээнд их хэмжээний мөнгө бий болж, барааны тоо хэмжээ бага байгаагаас үнэ өсөх
В. Үйлдвэрлэлийн зардал өсөх
С. Хөрөнгө оруулалт, цалин хөлсийг үндэслэлгүй өсгөх
D. Гол нэр төрлийн барааны хомсдол, үнийн огцом өсөлт
E. Бүгд зөв
31. Төрийн эдийн засагт гүйцэтгэх үүрэгт онц хамааралгүй нь аль вэ? (1 оноо)
А. Эдийн засгийн амьдралд хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх
В. Төгс өрсөлдөөн өрнөх таатай нөхцлийг бүрдүүлэх
С. Өмчийн харилцааг хөгжүүлэх
D. Эдийн засгийг тогтворжуулах
E. Орлогыг дахин хуваарилах
32. Эдийн засгийн хямралын үед ажилгүй болсон хүн ажилгүйдлийн ямар хэлбэрт багтах вэ? (1 оноо)
А. Бүтцийн ажилгүйдэл В. Шилжилтийн ажилгүйдэл
С. Мөчлөгийн ажилгүйдэл D. Завсрын ажилгүйдэл
E. Байнгын ажилгүйдэл
33. Монголын эдийн засгийн хуучин тогтолцоог өөрчлөх болсон гол шалтгаан аль нь вэ? (1 оноо)
А. Хувийн өмчийг үл зөвшөөрдөг учраас хүний эдийн засгийн эрх чөлөөг хаан боогдуулж, энэ чанараараа үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт хязгаарлагдмал байсан
В. Хэрэглээ хуримтлалын тэнцвэр алдагдсан
С. Эдийн засгийн хэт зардалт үрэлгэн байдал давамгайлсан
D. Өөрийн хуримтлалаараа өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулж чадахгүйд хүрсэн
E. Бүгд зөв
34. Эдийн засгийн бүх системд тулгарч буй бэрхшээлтэй гол асуудал-тай холбоотой. (2 оноо)
А. Шинэ техник технологийн шинэчлэл хийх В. Хэт үйлдвэрлэлийг багасгах
С. Олон янзын хэрэгцээг хязгаарлагдмал нөөц баялгаар зүй зохистой хангах
D. Эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээг зохицуулах E. Үнийн өсөлтийг хязгаарлах

35. Микро эдийн засгийн судалгаа аль нь вэ? (1 оноо)
А. Японы үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлт
В. Монголын дотоодийн нийт бүтээгдэхүүний өсөлт
С. Солонгосын авто машины зах зээлийн үнэ
D. Америкийн гадаад хөрөнгө оруулалтын бодлого
E. Дээрх бүгд
36. Нийгмийн давхраажилтын зөв тодорхойлолт аль нь вэ? (2 оноо)
А. Нийгмийн доторх ард иргэд, бүлгүүдийн эрх мэдлийн хэмжээ
В. Нийгмийн анги бүлэг, өмч хөрөнгө, эрх мэдэл, нэр хүндээрээ дээр доор байрлах байдал
С. Орчин үед нийгэмд баян, хоосны ялгаа гарсан
D. Ангиудын дотоодод соёлын ялгарал гарсан
E. Бүгд зөв
37. Боолчлол, каст, язгуур хэмээх давхраажлын хэв маяг ямар нийгмийг илэрхийлэх вэ? (1 оноо)
А. Нээлттэй нийгэм В. Иргэний нийгэм С. Хаалттай нийгэм
D. Боолын нийгэм E. Аль нь ч биш
38. Нийгмийн шилжих хөдөлгөөн юунаас үүдэн гарах вэ? (1 оноо)
А. Хүн амын ядуурлаас В. Нийгмийн давхраажилтаас
С. Эд хөрөнгийн ялгаанаас D. Тэгш байдал
E. Бүгд зөв
39. Нийгмийн давхрааны ялгаанд аль нь хамааралгүй вэ? (1 оноо)
А. Боловсролын түвшин В. Орон сууц С. Цалин, орлогын хэмжээ
D. Намын харъяалал E. Эрх мэдэл
40. Нийгмийн халамжид түлхүү хамааралтай нь хэн байх вэ? (1 оноо)
А. Тэтгэвэрт гарсан В. Бүтэн өнчин хүүхэд С. Тэнэмэл хүүхдүүд
D. Ажилгүйчүүд E. Дээрх бүгд
41. Давхраажилтын үндсэн хэв маягт аль нь тохирохгүй вэ? (1 оноо)
А. Боолын В. Иргэний С. Кастын D. Анги, бүлгийн E. Язгуур угсааны
42. Нийгмийн тэгш бус байдалд нөлөөлдөг хүчин зүйлс аль нь вэ? (1 оноо)
А. Нийгэмд гарч буй хөдөлмөрийн хуваарын өөрчлөлт
В. Хүмүүсийн амьдрах орчны ялгаа
С. Эрхлэх аж ахуй
D. Нийгмийн баялгаас хүртэх боломж харилцан адилгүй
E. Дээрх бүгд
43. Соёлыг бүрдүүлэгч зүйлсэд аль нь тохирох вэ? (1 оноо)
А. Хэл, мэдлэг В. Итгэл үнэмшил ба эдийн соёл С. Шашин шүтлэг
D. Ёс суртахуун E. Бүгд
44. Бүтээсэн хүмүүс нь тодорхойгүй, авьяаслаг хүмүүс бүтээсэн соёл аль нь вэ? (1 оноо)
А. Элитийн соёл В. Ардын соёл С. Зонхилох соёл D. Дагуул соёл E. Сөрөг соёл
45. Зонхилогч соёлын тодорхойлолт аль нь вэ? (2 оноо)
А. Нийгмийн бүлэг бүрийн өөрийн гэх үнэлэмж, зан байдлын дүрмүүдийн цогц
В. Ноёлогч үнэлэмжүүдтэй зөрчилдөж, түүнийг сөрж байдаг дагуул соёлын хэлбэр
С. Нийгмийн гишүүдийн олонхийн дагаж мөрддөг үнэлэмж, итгэл үнэмшил, уламжлал, зан заншлын цогц
D. Хүмүүсийн хэрэгцээг хангахад чиглэгдэн бүтээгдэж байгаа болон урьд нь бүтээгдсэн оюуны, эд өлгийн үнэт зүйлсийг хэлнэ
E. Бүгд зөв

46. Соёлын хэм хэмжээ гэсэн ойлголтод хамааралгүй зүйл аль нь вэ? (1 оноо)
A. Эцэг, эх, өтгөс, бууралаа хүндлэх B. Хууль ёсыг дээдлэх
C. Зан заншил D. Фиолософи E. Уламжлал
47. "Алдарт аялагч Марко Полотой цуг явсан хятад тогооч Италид спагеттийн жорыг авчирсан ба хожим нь Италийн цагаачид Америкт дэлгэрүүлжээ. Энэ нь аль ойлголтод холбогдох вэ? (2 оноо)
A. Соёлын өөрчлөлтийн эх үүсвэр B. Соёлын диффузи буюу нэвчилт
C. Соёлын олон талт байдал D. Соёлын универсал
E. Этноцентризм
48. Соёлын босоо чиглэлийн ангилалд аль нь тохирохгүй вэ? (1 оноо)
A. Элитийн соёл B. Ардын соёл C. Нийтийн соёл D. Оюуны соёл E. Бүгд зөв
49. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ? (1 оноо)
A. 1967 B. 1948 C. 1945 D. 1962 E. 1954
50. Монгол улс НҮБ-д хэдэн онд гишүүнээр элссэн вэ? (1 оноо)
A. 1972 B. 1961 C. 1992 D. 1921 E. 1946
51. Монгол улсын гадаад улс төрийн бодлогын тэргүүлэх чиглэл аль нь вэ? (2 оноо)
A. АНУ, Европын холбоо B. БНХАУ, ОХУ C. БНХАУ, АНУ
D. ОХУ, Европын холбоо E. Энэтхэг, Сингапур
52. Олон улсын харилцааны субъектүүдэд аль нь тохирохгүй вэ? (1 оноо)
A. Төр B. Ард түмэн C. Олон улсын байгууллага
D. Үндэстэн дамнасан корпораци E. Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК
53. Эрх мэдлийг үүргээр нь хуваарилах онолын зөв хувилбарыг олно уу? (2 оноо)
A. Хууль тогтоох, шүүх, хянах B. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
C. Хууль тогтоох, сонгох, шүүх D. Хууль тогтоох, улс төрийн шүүх
E. Гүйцэтгэх, шүүх, сонгох
54. Эрх зүйт төрд хуулийг баталдаг субъект болно. (2 оноо)
A. Ерөнхийлөгч B. Үндсэн хуулийн шүүх
C. Парламент D. Засгийн газар E. Үндсэн хуулийн цэц
55. Шүүхийн өмнө хэн эрх тэгш байх вэ? (1 оноо)
A. Хүн бүр B. Эрх зүйн бүрэн чадамжтай хүн ам C. Бүх хүн
D. Хууль ёсоор оршин суугаа хүн бүр E. Дээрх бүгд
56. Монгол улсын бүрэн эрхт байдлын зөв томъёолол аль нь вэ? (2 оноо)
A. Үндэсний эв нэгдлийг эрхэмлэсэн бүрэн эрхт тусгаар тогтносон улс мөн
B. Үндэсний тусгаар тогтнолыг эрхэмлэсэн бүрэн эрхт улс мөн
C. Тусгаар тогтносон, бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн
D. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн тусгаар улс мөн
E. Бүрэн эрхт улс мөн

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Өгөгдлийг тохируулна уу?

(5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|--|--|
| a. Нийгмийн шилжих хөдөлгөөн | 1. Тухайн давхрааны статус өөрчлөгдөх тохиолдолд хамт олноороо хөдөлгөөнд орох явдал |
| b. Босоо маягийн шилжих хөдөлгөөн | 2. Хувь хүн нийгмийн нэг үе давхраанаас нөгөөд, эсхүл нэг түвшингээс нөгөөд шилжих шилжилт |
| c. Хэвтээ хэв маягийн шилжих хөдөлгөөн | 3. Тодорхой хүний нийгмийн байр суурь өөрчлөгдөх байдал |
| d. Бүлгийн шилжих хөдөлгөөн | 4. Доороос дээш өгсөх болон дээрээс доошлох хоёр чиглэл бүхий шилжилт |
| e. Хувь хүний шилжих хөдөлгөөн | 5. Нийгмийн давхраажилын бүтэц, түүнд хувь хүн, нийгмийн бүлэг ямар байр суурь эзэлж буй, тэдгээрийн нийгмийн статус нь яаж өөрчлөгдөж байгаа зэргээр тодорхойлогддог хүмүүсийн нийгмийн байр суурийн өөрчлөлтийн цогц |

2.2. Ардчилсан бус тогтолцооны зөв хариултыг тохируулна уу?

(5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|----------------------|--|
| a. Нэг үзэл суртал | 1. Тухайн улс орны хэмжээнд ганц намын тогтолцоонд үйлчилсэн, улс төржсөн ҮЭ, залуучуудийн болон хүүхдийн байгууллага оршихыг зөвшөөрдөг. Мөн хянах албадах үүрэгтэй тогтолцоо оршино. |
| b. Улс төрийн систем | 2. Бүх өмчийг нийгэмчилж, амины өмчийг зөвшөөрдөг ч хувьдаа бусдаас илүү зүйлтэй байхыг үл зөвшөөрнө. Чөлөөт өрсөлдөөний тухай ойлголт байхгүй |
| c. Нийгмийн бүтэц | 3. Сурагчид пионерийн гишүүнд элсэхдээ “ Марксизм-ленинизм, пролетарийн интернационализм”-д үнэнч байхаа тангарладаг.Нийгмийн хичээлээр Марксизм-ленинизмийн онолыг номлодог байв. Номлолыг зөрчвөл “дайсан”болно. |
| d. Эдийн засаг | 4. Хувь хүн төрийн бүх талын хяналтад, бүрэн хараат байдалд оршино. Монгол улсын ажилчин анги нийгмийн манлайлагч хүч болдог. “ Орон бүхний пролетари нар нэгдэгтүн” уриан дор ажилчин ангийг бусад ангиас дээгүүр үзнэ. |
| e. Намын систем | 5. Нэг намын хувааргүй ноёрхол |

2.3. Өгөгдлийг тохируулна уу?

(5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|--------------------------------|--|
| a. Эрх зүйт төр | 1. Иргэдтэйгээ харилцах ёс журам, төр удирдлагын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх аргын асуудлыг хамарсан ойлголт |
| b. Социал төр | 2. Төрийг тэргүүлж дээд эрхийг барих ёс журмыг тогтоож ирсэн төрт ёсны дэлхий нийтийн уламжлалт тогтолцоо |
| c. Төрийн хэлбэр | 3. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанар буюу төр, иргэний нийгэм хоёр хууль эрх зүйн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга загвар |
| d. Төрийн байгууламжийн хэлбэр | 4. Тухайн орны нутаг дэвсгэр, засаг захиргааны бүтэц, нэгжийн хууль зүйн статус, төрийн төв болон орон нутгийн байгууллагын хоорондын харилцааны журам |
| e Төрийн дэглэм | 5. Хүмүүсийг амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн нийгмийн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маяг |

2.4 Өгөгдлийг тохируулна уу?

(5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|---------------------|--|
| a. Өмч | 1. Хүн төрөлхтний түүхэн дэх өмчийн анхны хэв маяг |
| b. Нийтийн өмч | 2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчлөлд буй зүйлс |
| c. Төрийн өмч | 3. Аливаа этгээдэд байж болох, үнэлж болох, материаллаг болон оюун санааны үнэ цэнэтэй зүйл |
| d. Орон нутгийн өмч | 4. Нийгмийн баялгийн тодорхой хэсгийг шудрагаар олж авч өөрийн болгон түүнийгээ мэдэж захиран зарцуулах туйлын эрх эдлэх явдал |
| e. Хувийн өмч | 5. Улсын болон төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгөө бүрдүүлж үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа хэлбэр |